



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/71

Даланзадгад сум

Томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн
тусламж үйлчилгээг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 12.2.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Журам, заавар батлах тухай” 373 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өмнөговь аймгийн хэмжээнд тархвар судлалын 46 дугаар долоо хоногт амбулаторийн үзлэгийн 25,4 хувийг томуугийн шалтгаант тохиолдол эзэлж, улирлын томуугийн цар тахлын хүндрэлийн үнэлгээгээр “АЛАГ ЦООГ” дэгдэлтийн түвшинд хүрсэн тул бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд өдөр бүр эмнэлзүйн тандалтыг тогтмол хийж, томуугийн үе шат бүрд тохирсон хариу арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, эрсдэлт бүлгийн хүн амын гэрийн эргэлтийг сайжруулж, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын нөөцийг бүрдүүлэх, хүний нөөцийг зөв төлөвлөж тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэж ажиллахыг нийт эрүүл мэндийн байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

2.2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 4 долоо хоногийн хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүүхдийн амбулаторийн цагийг 09:00-19:00 хүртэл, өрхийн эрүүл мэндийн төв, Цогтцэций, Ханбогд сумын эрүүл мэндийн төвүүд амбулаторийн цагийг 09:00-20:00 хүртэл уртасгасан цагаар, амралтын өдөр (Бямба гариг) өрхийн эрүүл мэндийн төвүүд 10:00-16:00 цаг хүртэл богиносгосон цагаар ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, холбогдох сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, удирдлагуудад даалгасугай.


3.Уртасгасан болон богиносгосон цагаар ажиллах эмч, эмнэлгийн ажилтныг томилж, үүрэгжүүлэх, шаардлагатай цалин, урамшууллыг эмнэлгийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан шийдвэрлэж ажиллахыг бүх эрүүл мэндийн байгууллагын дарга нарт даалгасугай.

462501351

4.Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй хүүхдийн хувийн эмнэлэг, эмийн сангууд уртасгасан болон богиносгосон цагаар ажиллаж буй Бүсийн оношилгоо эмчилгээний төв, харьяа өрхийн эрүүл мэндийн төвийн цагийн хуваарьтай уялдуулан цагийн хуваарьтаа өөрчлөлт оруулж иргэдэд чирэгдэлгүй үйлчлэхийг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага болон эмийн сангийн дарга нарт зөвлөсүгэй.

5.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын нийт хэлтэс, төвийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ